

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ТӨВ НОМЫН САН**



# **ШИНЭ НОМЫН МЭДЭЭ**

**№10**


**2012.12.20**

**Эмхтгэсэн: Ном зүйч М. Кунай**

**Ном зүйч Д. Алтанзул**

**Электрон каталоги:  
<http://catalog.num.edu.mn>**

## ГЕОМЕТР, ОДОН ОРОН СУДЛАЛ



Мягмаржав С. **Фрактал бүтэц** /Ред. А. Мекей., Ш. Энх-Амар. – УБ.: Ган принт, 2007. – 128 х.

Зохиогч С. Мягмаржавын бичсэн “Фрактал бүтэц” ном нь монгол хэл дээр гарч буй фрактал геометрийн талаарх анхны бүтээл юм. Фрактал гэдэг үг нь английн fraction-бутархай гэдгээс гаралтай бөгөөд, фрактал геометр нь “бутархай хэмжээст олонлогийн геометр” гэсэн санааг илэрхийлнэ. Энэ ном нь фрактал геометрийн үндэстэй танилцахад зориулагдсан болно.

22.151.3

М-98

/БШУН унш-7ш/

T-15993-15995

Мөнх-Очир. **Монголын одон орон, зурхай судлалын түүх** /Хян. Л. Түдэв. – УБ.: 2012. – 470 х.

Зурхай гэдэг нь нар сар, од гарагийн орчил хөдөлгөөн байршил сансар ертөнцийн давтамжит зүй тогтол болон хүн, байгаль, дэлхийн харилцан нөлөөллийн холбоог танин мэдэх шинжлэх ухаан юм. Зурхай судлаач доктор Д. Мөнх-Очирын туурвисан энэхүү номонд монголын эртний улсуудын одон орон, зурхай судлалын мэдлэг ухаан болон одон орон, зурхай судлалд холбогдох дурсгалууд, монголын түүхэн дэх он тоолол ба цаглабар, монголын түүхэн дэх одон орон, зурхай судлаач эрдэмтэд, монгол одон орон, зурхай судлалын ном бүтээл ба бусад зүйлсийг судлан авч үзжээ. Мөн зурхайн үүсэл хөгжилт, хавсралтыг багтаажээ.


22.6г/1/

М-81

Б-22205-22207



## ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН



Адъяа Д. **Химийн нэвтэрхий толь** /Ред. Г. Баярмаа. – УБ.: Соёмбо принтинг, 2012. – 298 х.

Энэхүү толь бичигт химийн мэдлэг боловсролд чухал ач холбогдолтой 500 гаруй сонгомол сэдвүүдийн хажуугаар шинжлэх ухааны хялбарчилсан өгүүллэг, химийн түүхийн сонин баримтууд, инээдмийн шог, хошин зураг, бэсрэг өгүүллэг, бодисын гайхалтай сонин хувирлууд, эрдэмтдэд тохиолдсон хөгтэй явдал, ашигтай зөвлөгөө, багш нараас хичээл дээр тавьж үзүүлэх танин мэдэхүйн чухал, чухал туршлагын аргачлал, эд юмсын

гадаргууг алтдах, мөнгөлөх, никельдэх, гоёмсог өнгө суулгах, фото дүрс буулгах гэх зэрэг нэн сонирхолтой жишээ баримтуудыг оруулж өгчээ.

24я2

А-29

/БШУН унш-3ш/

Т-15984-15986


Энхтогтох А., Байгалмаа Ю. **Органик химийн дасгалын хураамж**: ЕБС-ийн XI ангийн суралцагч ба их, дээд сургуульд элсэгчдэд зориулав /Хян. Х. Хүрэлтогоо, Х. Отгонгэрэл. – УБ.: Соёмбо принтинг, 2012. – 148 х.

24.2я7


Э-66

/БШУН унш-7ш/

Т-15970-15972



## ГАЗАР ЗҮЙ



Буянбадрах Ч. **Монгол орны лавлах**: Хоёр дахь хэвлэл. – УБ.: Мөнхийн үсэг, 2012. – 605 х.

Энэхүү гарын авлагаас Монгол орны газар нутгийн онцлог, амьтан ба ургамал, байгалийн үзэсгэлэнт болон түүхэн дурсгалт газар, монгол улсын эртний, орчин цагийн түүх, монголчуудын дунд мөнхрөн үлдсэн өвөг дээдсийн намтар, эртний уламжлалт нүүдэлчин монгол ахуй, зан заншил, шашин шүтлэг, монголчуудын бэлгэдэл гэх мэт олон талын мэдлэг өгөхийг зорьжээ. Ялангуяа монгол хүнийг төлөөлөн ажиллаж буй чухал үүрэгтэй аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч нар, тус салбарын бусад мэргэжилтнүүд, гадаадын хөрөнгө оруулалтай компани, олон улсын байгууллагад ажиллаж буй мэргэжилтэн, орчуулагч нарт багагүй хувь нэмэр болох байх.

26.8г.я2

Б-81

/БШУН унш-6ш, Лав-1ш/

Т-15996-15998

Бямба Ж., Мөнхбат Ж. **Геологчийн гарын авлага**: Нэмж засварласан хоёр дахь хэвлэл /Ред. Л. Ганболд ба бус. – УБ.: Сэлэнгэ пресс, 2012. – 232 х.

Геологийн судалгааны ажил өргөжихийн хэрээр геологчдын өдөр тутмын хэрэгцээний гарын авлага болохуйц онол, практикийн лавлах материал зайлшгүй шаардлагатай болдог. Иймээс энэ нэмж засварласан хоёр дахь хэвлэлд тасралт эвдрэлийн зарим элемент, голлох эрдсийн химийн элементийн



агуулга зарим маркийн компас, GPS-ийн бүтэц зохион байгуулалт ба ажиллах зааврыг өгчээ.

26.3я2

Б-98

/БШУН унш-7ш/

Б-22183-22185

## **БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН**



Бямбасүрэн Д. **Айл гэрийн цэцэрлэг.** – УБ.: Урлах эрдэм, 2011. – 188 х.

Монгол орон хэдий хатуу ширүүн уур амьсгалтай ч эндээ зохицож идээшсэн мөнх ногоон мод, бутнаас эхлээд жимс, жимсгэнэ, цэцэг навч гээд олон төрөл бий. Энэ бүхнийг оновчтой цогцлуулж чадвал та бүхэн хаанаас ч дутахааргүй сайхан цэцэрлэгт орчныг бүтээж чадна. Тиймээс энэхүү үйлсэд чинь зориулан тус болох зорилгоор олон жил оролдсон ажлынхаа үр дүн, олж мэдсэн зүйлээс үндэслэн бичжээ.

28.5я6


Б-98

/БШУН унш-4ш/

Б-22202-22204

**Молекул биологийн үндэс:**Сурах бичиг /Ред. Бү. Дашням, В. Энхчимэг. – УБ.: Битпресс, 2012. – 168 х.

Энэ сурах бичгээс та молекул биологийн үндсэн онол, конценциуд, биологийн загвар систем, биологийн макромолекулууд, макромолекулуудын бүтэц, үүрэг, үйл ажиллагаа, үүргийн зохицуулга, молекул биологийн практик хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдлэг олж авах боломжтой.



28.070я73

М-68

/БШУН унш-7ш/

Т-15962-15964



Очирбат Г. **Эрдэм шинжилгээний бүтээлүүд**/1970-2010 онд монголоор бичсэн/:Боть.1 /Ред. У. Лигaa. – УБ.: Женерал принтинг, 2011. – 496 х.

Биологийн шинжлэх ухааны доктор, профессор Г. Очирбат ОХУ-ын Эрхүүгийн УИСийн биологи-ургамал судлаачийн мэргэжлээр 1967 онд төгсөж, ажлын гараагаа Шаамар дахь жимс жимсгэнийн станцад эрдэм шинжилгээний ажилтанаар эхэлснээс хойш 40 гаруй жил өнгөрч байгаа боловч өдий хүртэл энэ ажлаа үргэлжлүүлсээр яваа. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл, зарим илтгэлийг нэгтгэсэн энэ нэгдүгээр ботид зөвхөн монгол хэлээр

бичсэн зүйлийг хамруулан хэвлүүлжээ. Судлаач эрдэмтэн Г. Очирбат монголчуудын үе уламжлан мөрдөж байсан байгаль хамгаалах ёс заншлыг шинжлэх ухааны ач холбогдол, практик өгөөжийн талаас нь судлан дүгнэж бичсэн өгүүллүүд бүтээлд орсон нь залуучуудад монгол уламжлалаа ойлгож, сэргээн хөгжүүлэхэд тус болохуйц санаа өгөх ном болжээ.

28.5/1/

О-60

/БШУН унш-3ш/

Т-15987-15989

Фуцуима Дуглас Ж. **Эволюци**: Хоёр дахь хэвлэл /Орч. Ред. Б. Болдгив. – УБ.: Адмон, 2012. – 702 х.

Энэхүү ном нь анхны хэвлэлийн нэгэн адил бас л филогени ба эволюцийн түүхийн сэдвээр эхэлж, эволюцийн процессын олон талыг авч үзжээ.

28.02я73


Ф-96

/БШУН унш-35ш/

Т-15951-15955



## **МЭДЭЭЛЛИЙН САН**



Чимгээ Д ба бус. **MS Access-мэдээллийн сан удирдах систем**: Шинэчилсэн хоёр дахь хэвлэл. – УБ.: МУИС-ийн хэвлэх, 2012. – 276 х.

Энэ ном нь MS Access 2007 программыг анх судалж байгаа болон түүний өмнөх хувилбаруудыг ашиглаж байсан хэрэглэгчид ч ашиглахад ойлгомжтойгоор бичжээ. Энэ программын гол зорилго нь мэдээллийн сангийн сервер байдлаар холбоо хамаарал бүхий өгөгдлийн цуглуулгыг загварчилж, мэдээллийн санд өгөгдлүүдийг бодит баримтуудаас оруулж боловсруулалт хийж интерактив горимоор ашиглахад оршино.

32.973-018.2

Ч-62

/БШУН унш-15ш/

Б-22216-22220

## **ХӨДӨӨ АЖ АХУЙ**

Галт Л. **Ургамлын өвчин судлал**: Фитопатологи /Хян. Ц. Нямлхагва. – УБ.: Арвай принт, 2012. – 268 х.

Тус сурах бичиг нь ургамлын өвчин үүсгэгч, өвчний биохимийн үндэс, өвчин үүсгэгч, ургамлын өвчин, харилцан хамаарал, өвчин үүсгэгч, ургамлын өвчин хоёрын харилцан шүтэлцээ хэмээх гурван хэсэг 14 бүлэгт багтаажээ.



Фитопатологи нь бактери, мөөгөнцөр, вирусээр өдөөгдөх ургамлын өвчинг судлана. Энэ сурах нь мэргэжлийн сургуулийн оюутан сурагчид, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан, төрөл бүрийн хүнсний үйлдвэрийн мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын албаны мэргэжилтэн зэрэг шинжлэх ухааны олон салбарын ажиллагсад өргөн ашиглахад зориулагдсан хамгийн сүүлийн үеийн ололтонд тулгуурлан бичигджээ.

44.7

Г-20

/БШУН унш-7ш/

T-15957-15959



**Больхорлоо Д ба бус. Бэлчээрийн монгол мал үржүүлэх арга ухаан** :Монгол мал үндэсний хөтөлбөрт зориулав /Хян. Д. Чойжил. – УБ.: Хайтан, 2011. – 441 х.

Монголын мал аж ахуйн мэргэжилтэн, малчид олон зууны турш бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн амьдрахдаа малын өвчин согогийг оношилж, эмчлэн эдгэрүүлэх ихээхэн мэдлэг туршлага хуримтлуулан, ардын уламжлалт мал эмнэлэгийг үүсгэн хөгжүүлсэн бөгөөд орчин үед ардын мал эмнэлэгийг шинжлэх ухааны мал эмнэлэгтэй оновчтой хослуулан хэрэглэж, мал аж ахуйд өөрчлөлт, шинэчлэлтийг хийсэн байна. Энэхүү бүтээлээ таван бүлэгт хуваан авч үзжээ. Үүндээ: мал аж ахуйн үйлдвэрлэл, цаг агаар, малын хариулага, маллагаа, монгол малчны арга ажиллагаа, туршлага, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийн асуудлууд, төр засгийн бодлого, мал сүрэг гэсэн бүлгүүдтэйгээр мал аж ахуйн мэргэжилтэн, оюутан, залуу малчдад зориулан гаргажээ.

45.4/1/

Б-94

/БШУН унш-6ш/

Б-22158-22160

**Шархүү Г. Мал эмнэлэгийн паразит судлал малын инваз өвчнүүд:**Товч сурах бичиг /Ред. Г. Нямдаваа. – УБ.: Согоонуур, 2011. – 239 х.

Сурах бичигт манай орны эдийн засагт нилээд хохирол учруулдаг мал амьтны инваз өвчнийг хамарсан онол, практикийн ач холбогдолтой мал эмнэлэгийн паразит судлалын үндсэн материалыг оруулж өгчээ. Паразит судлалын хичээлээр паразитын хэлбэр зүй, үржил хөгжлийн онцлог, ангилал, өвчний эпизоотологи, эмгэг жам, эмнэл зүйн шинж тэмдэг, биеийн бүтцийн эмгэг, хувиралт, онош, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга




хэмжээ зэргийг судлаж, мал эмнэлэгийн паразит судлалын үндсэн мэдлэгтэй болно.

48я73

Ш-31

Б-22214

## ЭДИЙН ЗАСАГ



Батцэнгэл А., Намжилмаа Д. **Эдийн засгийн дээд математикийн гарын авлага**: 2-р дэвтэр /Ред. Ү. Бадам. – УБ.: Бит пресс, 2009. – 264 х.

Энэхүү гарын авлагын бүлэг бүр нь 2 хэсэгтэй бөгөөд эхний хэсэгт онолын материалыг холбогдох жишээ бодлогуудын бодолтын хамт оруулсан ба сүүлийн хэсгийн бүлэг сэдэвт холбогдох бие дааж бодох бодлогуудыг оруулжээ.

65.23я73

Б-34

/БШУН унш-7ш/

Б-22208-22210

Жавзандулам С., Олзбаяр Г. **Идэвхижүүлэлтийн удирдлага**: Их дээд сургуулийн оюутан, маркетингийн мэргэжилтэн, бизнес эрхлэгч нарт зориулав. – УБ.: 2012. – 219 х.



Энэхүү номд идэвхижүүлэлтийн үндсэн арга хэрэгсэл болох зар суртачилгаа, борлуулалтын таамаглал, олон нийтийн харилцаа болон шууд маркетингийн тухай ойлголтыг дэлгэрүүлэн авч үзэж, практикт хэрэглэх боломжуудыг тодорхой бодит жишээ үзүүлсэн нь ойлгоход хялбар тус дөхөмтэй. Мөн бүлэг бүлгээр мэдлэг шалгах тест болон идэвхижүүлэлтийн холбогдол бүхий мэргэжлийн үг, хэллэгийн тайлбарыг англи хэл дээр боловсруулан хавсаргасан нь мэргэжлийн нэгдсэн хэллэгийг нийтэд хэвшүүлэх, бататгах ба бие даан идэвхижүүлэлтийн менежментийг судлахад туслана.

65.290-2

Ж-10

/НХШУН унш-3ш/

Т-15960-15961



Жонсон Р. **Бизнес төлөвлөгөө хийх аргачлал**: Таны бизнесээ эхлэхэд яг хэрэгтэй зүйл энэ номд бий /Англ хэлн орч. Б. Дашням. – УБ.: Битпресс, 2006. – 122 х.

65.290-2

Ж-79

/НХШУН унш-5ш/

Б-22163-22165

Мөнхзул Э. **Хувьцаа бондоор мөнгө босгох арга**:Цуврал-1 /Ред. А. Эрдэнэ. – УБ.: 2011. – 162 х.



Тус номыг Монголын хөрөнгийн биржийн 20 жилийн ойг тохиолдуулан хөрөнгийн биржийн сургалт, санхүүгийн зохицулах хорооны сургалтын материалуудыг өргөнөөр ашиглан иргэдэд анхан шатны мэдлэг өгөх үүднээс гаргажээ. Энэ цувралдаа монголд арилжигдаж байгаа хэрэгслүүд болох хувьцаа, бондын талаар мэдэгдэхүүнийг олж аван энэ хоёр хэрэгслийг ашиглан мөнгө босгох аргуудыг тусгажээ.

65.262.2

М-81

/НХШУН унш-5ш/

Б-22166-22170



Оргилон Д. **Стратегийн удирдлага**:Онол, хэрэглээ /Ред. П. Мөнх. – УБ.:Анар цэнт, 2011. – 170 х.

Стратегийн удирдлагын онол болоод судалгааны аргачлал нь маш өргөн хүрээг хамардаг. Бүтээлд стратегийн томъёолол, хэрэгжүүлэлт, хяналт гэсэн үндсэн гурван хэсэг бүхий 15 бүлэгтэй бөгөөд гол онцлог нь судалгаа шинжилгээний аргуудыг илүү түлхүү тайлбарлаж өгсөнд оршино. Жишээ нь орчны үнэлгээний түгээмэл болон тусгай аргууд, стратегийн шинжилгээ үнэлгээний аргууд, стратегийн сонголтын матрицууд, стратеги болон соёлын нийцлийг үнэлэх загвар, мөн байгууллагын төсөв, гүйцэтгэл, стратегийн хэрэгжүүлэлтийг үнэлэх систем зэрэг аргууд орсон байгаа нь оюутан, судлаачдын судалгаа шинжилгээний ур чадварыг дээшлүүлэхэд багагүй нэмэр үзүүлнэ.

65.290-2

О-41

/НХШУН унш-4ш/

Б-22136-22138

Отгонсүрэн Я. **Байгууллага хоорондын харилцааны маркетинг**: Судалгаа, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт. – УБ.: Адмон, 2012. -268х.



Энэ номонд байгууллагын зах зээлийн үндсэн бүрэлдэхүүн болох үйлдвэрлэгч, зуучлагч, засгийн газар ба ашгийн бус газрын маркетингийн онцлог, байгууллага-худалдан авагчийн зан төлөв, худалдан авах шийдвэр гаргах онцлог болон тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлийн хамаарал, байгууллагын зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах зүй тогтол, үйлчилгээг хоногшуулах стратеги, тактикийн асуудлуудыг гүнзгий авч судалсан төдийгүй бизнесийн харилцааны

маркетингийн үйл ажиллагааны практик удирдамж, арга зүйн зөвлөмжийг боловсруулан толилуулж байна. Энэхүү ном нь бизнесийн байгууллагын ажилтан, болон их дээд сургуулийн оюутан, магиструудад гарын авлага болж өгнө.

65.290-2

О-53

/НХШУН унш-11ш/

Т-15965-15969



Оюунчимэг Б. **Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх арга зам.** –УБ.: Мөнхийн үсэг, 2008. -188х.

“Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх асуудал”-ыг энэ номонд хөрөнгө оруулалтын удирдлагын онолын үндэс, бүс нутгийн барилга угсралтын байгууллагын хөрөнгө оруулалтын үр ашигт нөлөөлөх дотоод, гадаад хүчин зүйлсийн судалгаа, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх бүс нутгийн барилга угсралтын байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх арга зам гэсэн 3 бүлэгт авч үзжээ. Энэхүү судалгааны ном нь барилга, эдийн засгийн чиглэлээр сурч буй оюутан, магистр, докторуудын судалгааны ажилд гарын авлага болно.

65.31-56

О-63

/НХШУН унш-4ш/

Б-22080-22082

Өлзийбаяр В. **Глобал орчин ба өрсөлдөөн.** –УБ.: 2004. - 106 х.

Их, дээд сургуулийн менежментийн багш, энэ чиглэлээр сурч буй оюутан, судлаач, бизнес эрхлэгч нарт зориулагдсан энэ номны эхний хэсэгт глобал орчны өөрчлөлт хөгжлийн талаар, 2-р хэсэгт өрсөлдөх чадварын асуудлыг үндэстний болон бизнесийн нэгжийн түвшинд авч үзсэн ба улмаар глобал орчинд өрсөлдөх компаний стратеги төлөвлөлтийн асуудлуудыг хөндөж тавьжээ.



65.5

Ө-74

Б-22177-22179



Пүрэвсүрэн Ж., Халиун Г. **Хөрөнгө оруулалтын менежмент** /Ред. Ч. Энхбаяр. – УБ.: МУИС-ийн хэвлэх, 2012. – 102 х.

Энэхүү номноос зах зээлийн өрсөлдөөний нөхцөлд хөрөнгө оруулалтыг ойлгох, түүний шалгуур үзүүлэлт, хөрөнгө оруулалтын шинжилгээний арга зүйн талаар тайлбарласан буюу, ер нь хөрөнгө оруулалтын онол арга зүйн асуудал, эрсд

элийг үнэлэх санхүүгийн шинжилгээний аргууд, үнэт цаасны зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг ач холбогдол, гадаадын хөрөнгө оруулалт зэрэг бүлэг сэдвийг оруулж өгснөөс гадна монгол-англи бизнесийн нэр томъёог багтаасан болно.

65.268

П-91

/НХШУН унш-5ш/

Б-22191-22195

**Хүний нөөцийн менежмент** /Эмх. Г.Гантөгс. –УБ.: Бит пресс, 2012. -200х.



Хэн нь их маркетинг, сурталчилгаа сайтай вэ гэхээсээ илүү аль компани хүний нөөцийн тогтвортой систем үүсгэж чадсан бэ гэдгээрээ өрсөлдөх нь компанийн засаглалын үндэс ажээ. Толилуулан буй энэ номонд хүний нөөцийн менежментийн чиг хандлага, байгууллага дахь үүрэг, хүний нөөцийн бүрдүүлэлт, сонголт, ажлын шинжилгээ дизайн, хүний нөөцийг сургаж хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, цалин хөлс-урамшуулал, байгууллага дахь карьер төлөвлөлтийн асуудлуудыг авч үзжээ.

65.290-2

Х-82

/НХШУН унш-3ш/

Б-22139-22141



**Шуурав Я. Байгууллагын нийгмийн хариуцлага: Зарчим, хүрээ, зорилтууд.** –УБ.: Номтпресс, 2012. -112х.

Глобал компакт санаачлага, нийгмийн хариуцлагын ойлголт, түүний хүрээ, филантропын үйл ажиллагаа, шударга өрсөлдөөн, нийгмийн хариуцлагын удирдамж – ISO 260008 олон улсын стандарт, байгууллагын ёс зүй ба нийгмийн хариуцлага, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх арга замын тухай асуудлуудыг хөндөж бичсэн энэхүү ном нь удирдлагын академийн сонсогчид болон төр, захиргаа, бизнесийн байгууллагын ажилтан, менежер, оюутан, магистр, докторуудад зориулагджээ.

65.290-2

Ш-93

Б-22121-22123

**Шуурав Я., Сайнцогт Ч. Удирдлагын шийдвэр боловсруулахад экспертийн үнэлгээний аргыг хэрэглэх нь.** –УБ.: Номтпресс, 2011. -48х.

Удирдлагын академийн багш нарын бичиж, хэвлүүлсэн энэхүү товхимолд удирдлагын шийдвэр боловсруулахад



экспертийн үнэлгээний аргын мөн чанар, түүний агуулга., экспертийн үнэлгээний зарим аргын онцлог – хэрэглээ /дельфи, хос зэрэгцүүлэлт, консенсус, оюуны довтолгоо хэмээх аргууд/, экспертүүдийн санал нийлэлтийн түвшинг тодорхойлох тухай өгүүлжээ.

65.290-2

Ш-93

/НХШУН унш-5ш/

Б-22145-22149

## УЛС ТӨР СУДЛАЛ



Баянтөр М., Батцэнгэл В., Одхүү Н. **Улс төрийн газарзүй** /Ред. М.Баянтөр. –УБ.: МУИС-ийн хэвлэх, 2012. -183х.

Дэлхийн улс төрийн зураг., дэлхий улсуудын засаглалын хэлбэр ба хэв шинжийн ангилал., дэлхийн улсуудын эдийн засаг ба улстөрийн нэгдлүүд., олон улсын зарим байгууллагууд., дэлхийн улс төрийн зургийн бүрдэлт гэсэн

6 бүлгээс бүрдэх энэхүү сурах бичиг нь их, дээд, дунд сургуулийн багш, магистр, оюутан нарт зориулагджээ.

66.0

Б-38

/НХШУН унш-15ш/

Б-22116-22120

Билэгсайхан С. **Шинэтгэл, шинэ монгол.** –УБ.: Соёмбопринтинг, 2012. 366х.

Барилгын инженер мэргэжилтэй, ардчилсан үзэлтэн, УИХ-ын гишүүн асан, Монгол-Европын холбооны тэргүүн С.Билэгсайхан өөрийн намтар түүх, улс төрийн амьдралд хүчин зүтгэсэн он жилүүдийн дурсамж, сонин сэтгүүлд өгсөн ярилцлага, нийтлэл, илтгэл, хэлсэн үгнүүдээ эмхтгэн толилуулж байна. Амьдрал, тэмцэл, үйлс бүтээлийн замналын тухай өгүүлэх цуврал номын энэхүү тэргүүн дэвтэр нь энэ ажээ.



66.1/1/

Б-48

Т-15944-15946



Мөнхцэцэг Ц. **Политайнмент буюу цэнгээнт улс төр.** – УБ.: Соёмбопринтинг, 2010. -316х.

Зохиогч энэ номондоо улс төрийн бодлого, хэвлэл мэдээлэл, сонгогчдын зан үйл болон дэлхийн улс төрийн үйл явцын талаар сүүлийн 10-д жилд хэвлэн нийтлүүлсэн бүтээлээсээ оруулсан бөгөөд бэлгэ тэмдгийн улс төр, цэнгээнт улс төр, сонгуулийн кампанийн коммуникаци, улс төрийн ток шоу зэрэг

Монголын судалгаа шинжилгээний салбарт урьд өмнө судлагдаж байгаагүй шинэ асуудлуудыг хөндөж тавьжээ. Мөн дэлхийн түүхэнд хувь нэмрээ оруулсан улс төрчдийн түүхэн замнал, олон улсын харилцааны зарим нэг ээдрээтэй асуудлын талаарх тойм нийтлэлийг оруулжээ.

66.0

М-81

T-15947-15950

Энхбаяр Н. **Ард түмний дэмжлэг албан тушаалаас хүчтэй:** Нийтлэл, мэдэгдэл, хэлсэн үг, ярилцлага /Хян. М.Тэгшжаргал. –УБ.: 2012. -498х.



МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга, МАХН-ын дарга, УИХ-ын гишүүн, ерөнхий сайд, МУ-ын ерөнхийлөгч асан Намбарын Энхбаярын гаргасан мэдэгдэл, сонин сэтгүүлд хэвлүүлсэн нийтлэлүүд, янз бүрийн хурлууд дээр хэлсэн үг, сурвалжлагч нартай хийсэн ярилцлагуудыг нь эмхэтгэн уншигч олонд толилуулж байна.

66.1/1/

Э-66

T-15973-15975



Энхээ Ч. **Ардчилсан хөдөлгөөн:** Хөшигний арын нууц. – УБ.: 2010. -120х.


Монголд ардчилал байгуулсаны 20 жилд зориулан энэхүү номыг хэвлүүлжээ. Ардчилсан хөдөлгөөнийг үүсгэлцэж явсан, анхны удирдагчдын нэг Чимидийн Энхээ энэ номонд 1990-д оны ардчилалын төлөөх хөдөлгөөнд хэрхэн оролцсон, тухайн хөдөлгөөний зорилго, анхны ардчиллын хөдөлгөөний үйл явцын талаар тодорхой бичжээ. Тэрээр “МоАХ, МоАН-ын тухай бодол эргэцүүлэл” /1990/, “Ардчиллын төлөө 10 жил” /1998/, “Ардчилсан холбоо бид хоёр” /2008/ хэмээх номнуудыг бие даан хэвлүүлж байжээ.

66.75

Э-66

Б-22215

Эдлтон Ж. **Нэгэн чухал зүйл:** АНУ-Монгол улсын дипломат харилцаа 1987-2012 /Орч. Ц.Батмөнх. –УБ.: 2012. -201х.



АНУ-аас Монгол улсад суугаа элчин сайд Жонатан Эдлтоны энэ номонд 1987-2012 онд АНУ болон Монгол улс хоорондын дипломат харилцаа хэрхэн өргөжин, бэхжиж ирсэн талаар өгүүлжээ. Мөн түүнчлэн 1987-2012 онуудад АНУ,

Монгол улсын хооронд байгуулсан гол гол гэрээ хэлэлцээрүүд, элчин сайдууд ба алдабын дарга нар, хамтарсан мэдэгдэл, МУ-ын талаар АНУ-ын Сенатаас гаргасан тогтоолыг хавсралт болгон оруулжээ.

66.4

Э-19

/НХШУН унш-3ш/

Б-22142-22144

## ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ



**Олон улсын гэрээний тухай Монгол улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар** /Эрх.бэлт. П.Баяр. –УБ.: 2011. -239х.

Монгол улсын хууль зүйн алба болон дипломат алба үүссэний 100 жилийн ойд зориулан энэхүү номыг гаргасан ба энэ номонд 1993 оны 12-р сард дахин шинээр баталсан

“Олон улсын гэрээний тухай хууль”-д дэлгэрэнгүй тайлбар хийжээ.

67.412.1

О-29

/НХШУН унш-7ш/

Т-15976-15978

## БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Буянхишиг Ц., Ундрахгэрэл Ч. **Анги удирдсан багшид байх судалгааны арга зүй: 6-11, 12-18 насныханд.** –УБ.: Гэрэлт судар, 2010.

Энэхүү 2 ном нь сурагчдыг судлах арга зүй, анги танхимын орчны судалгаа гэсэн 2 бүлэгтэй бөгөөд сурагчдын сурах үйл ажиллагаа, анхаарал, ой тогтоолт, темперамент, зан төлөв, өөрийн санаа бодлоо илэрхийлэх чадвар, гэр бүлдээ хандах хандлага, бие даан ажиллах чадвар, хичээлийн ачаалал, хамт олны уур амьсгал, мөн суралцдаг анги танхимын агааржуулалт, гэрэлтүүлэг зэргийг тодорхойлох аргачлалуудыг нэгбүрчлэн авч үзжээ. ЕБС-ийн анги удирдсан багш нар болон багшлах эрдэмд сурч буй оюутнуудад энэхүү ном нь зориулагджээ.

74.202.4

6-11 насныхан. -46х.

Б-22186-22187

Б-81

12-18 насныхан. -55х.

Б-22188-22190





Ганбат Х. **Багшийг ажлын байранд хөгжүүлэх онол, арга зүйн асуудал**: Е–сургалтын жишээн дээр /Ред. О.Пүрэв. – УБ.: Битпресс, 2012. -124х.

Хөдөө орон нутгийн багшлах боловсон хүчнийг сургуульд нь, ажлын байранд нь хөгжүүлэх, боловсрол, мэргэжлийг нь дээшлүүлэхэд орчин үеийн мэдээлэл харилцааны технологийг ашиглан Е-сургалт зохион байгуулж байгаатай холбогдуулан толилуулж буй энэхүү ном нь боловсролын байгууллагын хүний нөөцийн менежментийн онол арга зүйн зарим асуудал., орон нутагт ЕБС-ийн багшийг ажлын байранд нь е-сургалтаар хөгжүүлэх араг зүйг судалсан нь гэсэн 2 бүлгээс бүрдэх ажээ. Бүх шатны сургуулийн тэр дундаа ЕБС-ийн нийт багш, удирдах ажилтнууд өөрсдөө бие даан боловсрох буюу ажлын байрандаа хөгжихөд нь энэхүү ном гарын авлага болох ажээ.

74.204

Г-21

/НХШУН унш-2ш/

Т-15979-15980

Ичинхорлоо Ш. **Орчин үеийн хичээлийн тухай өгүүлэх нь.** –УБ.: 2011. -82х.

Энэхүү товхимолд хичээл гэж юу болох, түүнийг яаж сурагч төвтэй болгох талаар зарим нэг үзэл санаа арга замыг дэвшүүлж, түүнийг яаж хэрэгжүүлэх талаар өгүүлжээ. Үүнд хичээл түүний мөн чанар, хичээлийн төлөвлөгөө, технологи, хувилбарууд, дүн шинжилгээ, хичээл дээр сурагчдыг багаар ажиллуулах арга зүй, хичээлээс гадуур зохиох сургалт-хүмүүжлийн ажлууд, гэрийн даалгаварын талаар багш болох оюутан, ЕБС-ийн багш нарт зориулан маш дэлгэрэнгүйгээр өгүүлжээ.

74.26

И-96

/НХШУН унш-3ш/

Б-22196-22198



Ичинхорлоо Ш. **Сурах арга.** –УБ.: Соёбмо принтинг, 2012. - 46х.

Цаг үе их мэдлэгтэй төдийгүй харин мэдлэгийг бие дааж олж эзэмших, мэдлэг чадвараа өөрөө байнга дээшлүүлэх, шинэ мэдлэгийг бүтээх чадвартай тийм хүнийг шаардах болсон өнөө үед сурах аргын тухай ухагдахуун, түүний төрөл, сурах аргыг сурагчдад хэрхэн эзэмшүүлэх талаар өгүүлэх энэхүү ном нь өөрийгөө хөгжүүлэх, сурагчдыг сургах аргыг хайж буй уншигчдад гарын авлага болох ажээ.

74.202.5

Ичинхорлоо Ш. **Сургуулийн хөгжлийн зарим асуудал.** – УБ.: 2011. -52х.

Энэхүү товхимолд ЕБС-ийн талаар суурь ойлголт, сургуулийн амьдралд юу шинээр бий болж байгаа, юу нь хуучирсан, юу нь болохгүй байгаа, юуг өөрчлөх талаарх асуудлуудыг ЕБС-ийн тухай ухагдахуун, үйл ажиллагааны чиглэл, бүтэц, гарч буй өөрчлөлт, удирдлагын тогтолцоо түүнийг ардчилах арга зам, сургуулийн хөгжил, түүний үйл ажиллагааг үнэлэх гэсэн 7 хэсэгт хуваан авч үзжээ.

74.204

И-96

/НХШУН унш-3ш/

Б-22211-22212



## **ХЭЛ ШИНЖЛЭЛ**



Болбаатар Д. **Шинэ хятад үсгийн толь бичиг.** –УБ.: Соёмбо принтинг, 2012. -439х.

Орчин цагийн хятад хэлний 10 000 гаруй үг хэллэгийг агуулсан энэхүү толь бичигт БНХАУ-ын “ Шинэ ханз үсгийн толь бичиг”-ийн 10-р хэвлэлд орсон ханз үсгүүдийг багтааж монгол орчуулгыг оноосон бөгөөд зохиогчийн 2004 оны “Хятад монгол толь бичиг”-т орсон цөөнгүй дан ханз үсгүүдийг авч оруулжээ.

81.2Хят-4

Б-54

/НХШУН унш-15ш/

Б-22153-22157

Шагдарсүрэн М. **Монгол охь үгийн толь** /Ред. До.Цэнджав. –УБ.: Адмон, 2011. -448х.

Анагаах ухааны шинжлэх ухааны доктор, профессор, ард олондоо “элэгний” Шагдарсүрэн хэмээн нэрлэгдсэн, их эмч, мэс засалч, орчуулагч Маналжавын Шагдарсүрэн өөрийн бүтээлүүдээ 20 боть ном болгон эмхтгэн уншигч олондоо толилуулж байгаа ажээ. Тэрээр хүнд хэцүү ажлын хажуугаар анагаах ухаан, буддын гүн ухаан, Энэтхэг, Хятад, төвдийн гүн ухаан, дэлхийн сонгодог яруу найргаас эх хэлнээ орчуулж, мэргэжлийн томоохон толь бичгүүдийг хэвлүүлжээ. Түүний бүтээлийн энэхүү 10-р боть болох “Монгол охь үгийн толь” хэмээх номонд монгол хэлний үгийн



сангийн гайхамшиг охь болсон, урьд өмнө ном хэвлэлд хэвлэгдээгүй өвөрмөц хэллэг, хэлц үг, зүйр цэцэн үг, онч мэргэн үгсүүдийг эмхэтгэн, цагаан толгойн үсгийн дарааллаар эрэмблэн оруулжээ.

81.2М-4

Ш-15

/НХШУН унш-3ш/

Б-22173-22174

## УТГА ЗОХИОЛ



Байгалсайхан С. **XX зууны монгол өгүүллэгийн туурвил зүй** /Ред. Ч.Дагвадорж. –УБ.: Сэлэнгэ пресс, 2010. -172х.

Энэ бүтээлд XX зууны монгол өгүүллэгийн ур чадварын өсөлт, хөгжлийг 1920-1930, 1940-1960, 1960-1990, 1990-2000 хэмээн үечлэн авч үзсэн ба тэдгээрийг тодорхой бүтээл дээр тайлбарлан өгүүлжээ. Бүлэг бүрт өгүүллэгийн тоймыг авч үзэхдээ ерөнхий утга зохиолын төвшин, нийгмийн байдалд тайлбар хийж, зохиолчдын ур чадварын өсөлтөнд үнэлгээ өгчээ.

83.3/1/2

Б-17

Б-22161-22162

Баттөр Ш. **Монголын модернист уран зохиол**: Уран зохиол ба өнөөдөр /Ред. С.Байгалсайхан. –УБ.: Сэлэнгэпресс, 2010. -116х.


Зохиогч номныхоо “Монголын модернист уран зохиол” хэмээх эхний хэсэгт утга зохиолын тухай онолын ухагдахууныг түүнд дүйцэх тайлбар, уран зохиолын жишээгээр батлан үзүүлсэн ба “Уран зохиол ба өнөөдөр” хэмээх дараагийн хэсэгт тодорхой зохиол дээр онолоо бататган задлан үзүүлжээ.



83.3/1/2

Б-34

Б-22124-22126



Өрнөхдэлгэр Д. **Уран зохиолыг мэдрэхүй**: Уран зохиолын судлал шүүмжийн өгүүлэл, хөрөг, тэмдэглэл /Ред. Д.Галбаатар. –УБ.: Соёмбопринтинг, 2011. -160х.

Залуу судлаач Өрнөхдэлгэрийн энэ номонд өнөө цагийн монгол уран зохиол, яруу найргийн гол гол төлөөлөгч болох Г.Мэнд-ооёо, Б.Лхагвасүрэн, Ж.Лхагва, Г.Аюурзана, М.Уянсүх... нарын шүлэг, зохиолд хийсэн задлан шинжилгээ, уран зохиолыг мэдрэх, ойлгох хэмээх онолын тайллууд, Г.Санжжав, Б.Баасанжав, Х.Цэдэв нарт зориулсан хөрөг нийтлэлүүд оржээ.

**УРАН ЗОХИОЛ**

Ги де Мопассан. **Сураггүй бологч**: Өгүүллэг, тууриуд /Орч. Д.Цоодол., Ред. Д.Тэмүүлэн. –УБ.: Жиком пресс, 2012. -407х.




19-р зууны Францын нэрт зохиолч Ги де Мопассаны энэ номонд Хүний үр, Александр, Сахиул, Гэрээслэл, Манай эзэгтэй, Розали хатагтай, Сураггүй бологч, Жюль авга, Бэлэвсрэл, Аймшигт амьтан, Хулгайч зэрэг нийтдээ 53 өгүүллэг, тууриуд оржээ.

84/4Фр/-44

М-71

/НХШУН унш-7ш/

Б-22133-22135



Дарьсүрэн Лха. **Онцгой эрх**. 2-р дэвтэр: Хүний нутгийн хөрс хатуу. –УБ.: 2011. -407х.

Лха.Дарьсүрэн нь 1936 онд Ховд аймагт төрсөн бөгөөд 1960-д оноос уран зохиол бичиж эхэлжээ. Тэрээр “Ханан дээрх сүүдэр”, “Танихгүй танилуудын золголт”, “Улаан дэнлүүний хагацал”, “Богд эзний зарлигаар”, “Үхэл сөрсөн хүмүүс”, “Хар тамхины дэнчин” зэрэг адал явдалт номыг хэвлүүлж, “Онцгой эрх” зохиолоороо НАХЯ-ны шилдэг уран бүтээлийн шагналыг хүртэж байжээ.

84/1/2-44

Д-38

Б-22127-22129

**Өрнө дорнын шилдэг өгүүллүүд** /Орч. Юмсүрэн Т. –УБ.: Соёмбопринтинг, 2012. -480х.



Энэ номонд өрнө дорнын алдартай зохиолчид болох Ч.Айтматов, А.Бламан, И.Бунин, А.Чехов, Л.Карнес, А.Феррес, Д.Буцатти, У.Фолкнер, Ж.П.Сартр, А.М.Омар, А.Несин, К.Чандар, Г.Сингх, М.Р.Ананд, Р.Таагүүр, А.Товареш телеш, Акутагава, Кэнзбури, Т.Хара, Я.Каваато нарын 35 зохиолчийн 80 гаруй шилдэг өгүүллүүд оржээ.

84/0/-44

Ө-90

/НХШУН унш-3ш/

Б-22130-22132

## ХЭЭ УГАЛЗ, ГҮН УХААН СУДЛАЛ



Төмөрхуяг Ж. **Хээ угалз бүтээх аргууд**: Монгол, англи, хятад хэл дээр. -УБ.: Мөнхийн үсэг, 2010. -165х.

Монгол ахуйг хээ угалзгүйгээр төсөөлөх аргагүй билээ. Монголчууд хээ угалзын сонгодог хэв маягийг буй болгосон төдийгүй амьдрал ахуйдаа өргөн хэрэглэдэг ард түмэн.

Толилуулан буй энэхүү өнгөт зурагтай номонд зохиогч Ж.Төмөрхуяг сүүлийн 15 жилийн туршид өөрийн бүтээсэн болон “Сэтгэмж” дизайны дээд сургуулийн шавь нарых нь бүтээсэн хээ угалзуудыг монгол, англи, хятад хэл дээр тайлбар хийж оруулжээ.

85.12

T-58

/НХШУН унш-3ш/

T-15981-15983

Даш-ёндон Б. **Цаг үе: Сэтгэл бодрол, философи** /Ред. Г.Чулуунбаатар. –УБ.: Соёмбо принтинг, 2012. -402х.

Зохиогч Б.Даш-ёндон өөрийн 1990-д оноос хойш орчуулсан материал, хурал дээр хэлсэн үг, сонин сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллүүдээ эмхэтгэн “Улс төр, ёс суртахуун”, “Түүх, хэл, соёл”, “Нийгмийн философид холбогдсон сэдвүүд” гэсэн 3 бүлэгт хуваан энэ номондоо оруулжээ. Улс төр, түүх, гүн ухаан судлаач нийт уншигчдын оюуны ертөнцийг философи, нийгмийн танин мэдэхүй, улс төр, ёс зүй, түүх, хэл, соёлын өргөн хүрээтэй мэдлэг, ухаалаг нухацтай бодол эргэцүүлэлээр баяжуулах ажээ.



87.3

Д-39

/НХШУН унш-7ш/

T-15990-15992

## СЭТГЭЛ СУДЛАЛ




Дэлгэржав М. **Эдийн засгийн сэтгэл судлал**. –УБ.: МУИС-ийн хэвлэх, 2012. -282х.

Эдийн засгийн сэтгэл судлал, эдийн засгийн зан төлөв, үйлдвэрлэлийн сэтгэл зүй, мөнгө, санхүү, үнэт цаасны зах зээл, татварын сэтгэлзүйн талууд, хэрэглэгчийн сэтгэл зүй, эдийн засаг-сэтгэл зүйн дасан зохицол хэмээх 6 бүлгээс

бүрдэх энэхүү ном нь сэтгэл судлал, бизнесийн сэтгэл судлал, эдийн засаг, банк санхүү, худалдааны мэргэжлийн ангийн оюутан, магистрант, докторантын заавал судлах хичээлийн үндсэн гарын авлагын зориулалттайгаар бичигджээ.

88.4

Оюунтунгалаг О. **“Мэргэжлээ сонгох уу? Мэргэжилдээ сонгогдох уу?”** /Хян. А.Баярцэцэг. –УБ.: 2010. -98х.



Мэргэжлээ зөв сонгоогүйгээс болсон азгүй туршлага, цаг хугацаа, эдийн засгийн болон хөлс, хөдөлмөрийн алдагдлыг та бишгүй дээ сонсож, бас харсан байх... Амьдралын хамгийн чухал үнэт зүйлсийн нэг болсон мэргэжлээ хэрхэн сонгох, хамгийн сайн шилдэг ажил мэргэжилтэй болоход тань мэдэж байх шаардлагатай чухал мэдээлэл, зөвлөмжүүдийг сэтгэл зүйн талаас нь энэ ном таньд тайлбарлаж өгөх болно.

88.4

О-63

/НХШУН унш-3ш/

Б-22171-22172



Оюунбилэг Т. **Сэтгэл заслын “48” аргууд.** –УБ.: Соёмбопринтинг, 2011. -111х.

Сэтгэл засал, түүний арга зүй., хувь хүний засал., бүлгийн засал., сэтгэл заслын аргууд., сэтгэлийн дотоод хүчийг бэхжүүлэх уламжлалт аргууд хэмээх 5 бүлгээс бүрдэх энэхүү номонд сэтгэл засал, түүний төрөл хэлбэрүүдийн тухай өгүүлж, практикт түгээмэл ашиглаж болох 48 арга дасгалыг оруулжээ.

88.4

О-63

/НХШУН унш-3ш/

Б-22150-22152